



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/290

Арвайхээр сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Биеийн тамир, спортын хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.7, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн 1.3.2.2, 1.3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, гавьяат тамирчин, дархан аварга Дашдоржийн Цэрэнтогтох агсны нэрэмжит, Монгол Улсын аварга цолны хүндэтгэлийн барилдааны зардалд 6,294,900 (зургаан сая хоёр зуун ерэн дөрвөн мянга есөн зуу) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх 6,294,900 (зургаан сая хоёр зуун ерэн дөрвөн мянга есөн зуу) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0549

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар
сарын 05-ны өдрийн 174 дугаар
захирамжийн хавсралт



ХҮНДЭТГЭЛИЙН БАРИЛДААНЫ ТӨСӨВ

Д/Д	Нэрс	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1.	Бай шагнал	1	5.264.000	5.264.000
2.	Хүндэтгэлийн арга хэмжээний зардал бусад			1.030.900
4	НИЙТ ДҮН			6.294.900

-oOo-